


ЗӨВШӨӨРӨВ:  
ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ  
ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ц.ЭРДЭМБИЛЭГ

БАТЛАВ:  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ  
УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААН СУДЛАЛЫН  
МЭРГЭЖЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ДАРГА



Д.ЦЭНД-АЮУШ

УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ИХ ЭМЧИЙН  
“ЗҮҮ ЭМЧИЛГЭЭ СУДЛАЛ”  
ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Мэргэшлийн индекс S(r) 091701  
Сургалтын хугацаа: 2 жил

УЛААНБААТАР ХОТ  
2022 ОН

## **БОЛОВСРУУЛСАН АЖЛЫН ХЭСЭГ:**

Б.Лагшмаа	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн, Монгол анагаах ухааны олон улсын сургуулийн, Зүү төөнө заслын тэнхимийн багш, зөвлөх зэргийн эмч, Анагаах ухааны доктор, дэд профессор
В.Энхтуяа	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн, Монгол анагаах ухааны олон улсын сургуулийн, Зүү төөнө заслын тэнхимийн эрхлэгч, ахлах зэргийн эмч, Анагаах ухааны доктор
Д.Шинэтуяа	Уламжлалт Анагаах Ухаан, Технологийн Хүрээлэнгийн Эмнэлгийн дарга, зөвлөх зэргийн эмч, Анагаах ухааны магистр
Б.Энхжаргал	Уламжлалт Анагаах Ухаан, Технологийн Хүрээлэнгийн Эмнэлгийн амбулаторийн их эмч, тэргүүлэх зэргийн эмч
Э.Уянга	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль, Монгол анагаах ухааны олон улсын сургууль, Зүү төөнө заслын тэнхимийн багш, Анагаах ухааны магистр
З.Энхзаяа	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль, Монгол анагаах ухааны олон улсын сургууль, Зүү төөнө заслын тэнхимийн багш, Анагаах ухааны магистр
Б.Номин	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн Эмнэлгийн хөгжлийн газрын арга зүйч, Анагаах ухааны магистр

## **ХЯНАСАН:**

П.Эрхэмбаяр	Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Нийгмийн эрүүл мэндийн магистр
Б.Туяа	Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн
Д.Дондогмаа	Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Хүний нөөцийн хөгжлийн албаны ахлах мэргэжилтэн, Анагаах ухааны магистр
М.Оюунчимэг	Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын Уламжлалт анагаах ухааны хэлтсийн Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээ хариуцсан ахлах шинжээч

Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн  
2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн  
32 дугаар тогтоолоор зөвшөөрөв.

УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ИХ ЭМЧИЙН  
**"ЗҮҮ ЭМЧИЛГЭЭ СУДЛАЛ"-ЫН**  
ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

**НЭГ. ҮНДЭСЛЭЛ**

Уламжлалт анагаах ухааныг сэргээн хөгжүүлэх төрийн бодлогын үндсэн чиглэл болон манай орны нийгмийн хэрэгцээ, өвөрмөц онцлогт зохицон ажиллах эмч мэргэжилтнийг бэлтгэхэд мэргэшүүлэх сургалтын агуулга, түүний түвшингийн үнэлгээний арга зүйг шинээр боловсруулах асуудал нэн чухал болж байгаа юм. Эрүүл мэндийн салбарт Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээний тогтолцоо батжиж, бэхжихийн хирээр уламжлалт анагаах ухааны тусламжийн хэрэгцээ жилээс жилд өргөжиж байна. Монгол улсын хэмжээнд төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгүүдэд уламжлалт анагаахын кабинет, тасаг ажиллаж улмаар өрхийн эмнэлэгт уламжлалтын эмч ажиллах боллоо.

Дорно дахины ард түмэн өвчин эмгэгийг мянга гаруй жилийн турш анагааж ирсэн зүү төөнө заслын оношилгоо эмчилгээний баялаг туршлагыг монгол эмч мэргэд эртнээс хэрэглэж ирсэн түүхэн уламжлалтай билээ. Хятад анагаах ухаан нь онолын тогтолцоо, эмнэлзүй, урьдчилан сэргийлэх анагаах ухаан гэсэн гурван хэсгээс бүрдэнэ. Уламжлалт анагаах ухааны онолд суурилсан зүү төөнө засал нь суралцаж эзэмшихэд ойлгомжтой, өөрийн өртөг бага, эмчилгээний өндөр үр дүнтэй, нотолгоонд суурилсан эмийн бус эмчилгээний арга юм. Хүн амын дунд зонхилон тохиолддог эмгэгүүдийг эмчлэхэд ДЭМБ-аас хүлээн зөвшөөрөгдсөн энэхүү эмчилгээний аргыг Монголын уламжлалт анагаах ухаан болон орчин үеийн анагаах ухааны оношилгоо эмчилгээний аргуудтай хавсран хэрэглэх, Уламжлалт анагаах ухааны онолын суурь мэдлэг, зонхилон тохиолдох өвчин эмгэгүүдийн эмгэг жам, эмнэлзүйн онцлогтой холбон тайлбарлах, зөвлөх чадвар бүхий мэргэжилтэнд эзэмшвэл зохих мэдлэг, эмнэлзүйн дадал зүйг тусгасан хөтөлбөр боловсруулав.

**ХОЁР. ЭРХЭМ ЗОРИЛГО**

Зүү төөнө заслын чиглэлээр эмнэлгийн тусламжийн шат бүрд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах өндөр түвшний мэдлэг, чадвар, хандлагатай мэргэжилтэн бэлтгэхэд оршино.

**ГУРАВ. АЛСЫН ХАРАА**

**Зүү эмчилгээ судлалын сургалтын хөтөлбөрөөр бэлтгэх эмчийн дүр зураг:**

Зүү төөнө заслын эмч нь Хятад анагаах ухааны болон орчин үеийн анагаах ухааны онолоор зонхилон тохиолдох өвчний оношилгоо, зүү эмчилгээний болон урьдчилан сэргийлэх анагаах ухааны мэдлэг, чадвар, хандлагыг эзэмшсэн,

эмчийн ёс зүйг чандлан баримталдаг, багаар ажиллан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг эрсдэлгүй, үр дүнтэй үзүүлж чаддаг байна.

## **ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН "ЗҮҮ ЭМЧИЛГЭЭНИЙ ЭМЧ"-ИЙН ЦОГЦ ЧАДАМЖ**

Алсын харааг биелүүлэхэд чиглэсэн дараах цөм чадамжтай байна:

1. Зүү эмчилгээний эмч байх (*Medical doctor of Acupuncture*)
2. Мэргэжлийн байх (*Professional*)
3. Тасралтгүй суралцагч байх (*Continous Learner*)
4. Харилцагч байх (*Communicator*)
5. Хамтрагч байх (*Collaborator*)
6. Хүн амын эрүүл мэндийн зөвлөгч байх (*Community Health Advocate*)
7. Зохион байгуулагч, манлайлагч байх (*Leader*)

Цөм чадамж бүхий эмч болохын тулд дараах чадамжийг эзэмшиж, бие даан гүйцэтгэж чаддаг болно. Үүнд:

### **1. Зүү эмчилгээний эмч:**

- Хүн амын дунд зонхилон тохиолдох өвчний шинж тэмдгийг таньж ялган оношлох
- Хятад анагаах ухааны онолыг бүрэн ойлгож таньсан, түүнийгээ оношилгоо, эмчилгээндээ ашиглаж чаддаг байх
- Эмчлүүлэгчээс асуумж авах, бодит үзлэг хийх, үйлчлүүлэгчийн сэтгэл зүй, нийгмийн нөхцөл байдлыг үнэлж уламжлалт анагаахын оношилгоо, идээ ундаа, явдал мөр, эм, заслын эмчилгээ хийн, хяналтын төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх
- Үйлчлүүлэгчийн хувийн нууцыг хадгалах
- Үйлчлүүлэгчийн өвдөлт, сэтгэл зовнилд анхаарал хандуулах
- Эрүүл мэндийн байгууллагын бүртгэл болон тайлангийн маягтыг зохих журмын дагуу цаг хугацаанд нь хөтлөх

### **2. Мэргэжлийн байх:**

- Мэргэжлийн ур чадвартай байх
- Орон нутаг, бүс нутагт өөрийн мэргэшлээр хувь нэмэр оруулах хүсэл эрмэлзэлтэй байх, хууль эрхзүйн дүрэм журмыг мөрдөж ажиллах
- Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхдээ эмчлүүлэгчийн хувь хүний хувьд хүндэтгэх, нэр хүндийг хамгаалан, хамгийн оновчтой зөв шийдвэр гаргахын төлөө ажиллах
- Хувь хүний онцлогийг харгалзан үйлчлүүлэгч болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, төрөл, садны хүнтэй хүндэтгэлтэй харилцах, эмчлүүлэгчийн эрсдэлийг үнэлэх, хянах чадвартай байх

### **3. Суралцагч байх:**

- Өөрийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлэхийн тулд хэрэгцээт сургалтад хамрагдах;
- Өдөр тутам шинэчлэгдэж байгаа шинжлэх ухааны дэвшлээс хоцрогдохгүйн тулд бие даан тасралтгүйгээр суралцах, олон төрлийн мэдээллийн эх үүсвэрийг судлах, дүн шинжилгээ хийх;

- Хамтран суралцагч эмч, бусад эмнэлгийн мэргэжилтэнд заах замаар өөрийн мэдлэг, ур чадвараа сайжруулах.

#### **4. Харилцагч:**

- Үйлчлүүлэгч болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, төрөл, садны хүнтэй зүй зохистой үг хэллэг ашиглан зөв боловсон харилцах;
- Үйлчлүүлэгчид шаардлагатай мэдээлэл өгөхдөө ойлгоход хялбар үг хэллэг ашиглан тайлбарлах;
- Шаардлагатай тохиолдолд эмчлүүлэгчийн оношилгоо, эмчилгээний талаар бусад эмнэлгийн мэргэжилтэнтэй зөвлөлдөх.

#### **5. Хамтрагч:**

- Тухайн орон нутгийн уламжлалт анагаахын тусламж, үйлчилгээтэй холбоотой асуудлаар мэргэшлийн эмч нартай мэдээлэл солилцож, хамтран ажиллах.
- Эмнэлгийн бусад тасгийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнтэй мэргэжлийн мэдлэг, мэдээллээ хуваалцаж хамтран ажиллах.

#### **6. Хүн амын эрүүл мэндийн зөвлөгч:**

- Хүн амын эрүүл мэндийн зөвлөгч байхын тулд урьдчилан сэргийлэх, тусламж үйлчилгээ үзүүлэх, сургалт сурталчилгаа явуулах;
- Хүн амын эрүүл мэндийн хэрэгцээнд тохирсон арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

#### **7. Зохион байгуулагч, манлайлагч:**

- Уламжлалт анагаахын тусламж, үйлчилгээг зохицуулах, манлайлан ажиллах үүргээ ухамсарлах;
- Эмнэлэг, эрүүл мэндийн төв дэх тусламж, үйлчилгээ үзүүлэх багийг манлайлан ажиллах үүргээ ухамсарлах.

### **ТАВ. СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ**

#### **5.1 Сургалтын чиглэл, хугацаа, байршил**

Сургалтыг:

1. Зүү төөнө заслын онол арга зүйн тойролт
2. Зүүний сүвийн хэмжил зүй
3. Зүү төөнө заслын оношилгоо
4. Зүү төөнө заслын аргууд
5. Зүү төөнө заслын эмгэг зүй
6. Зүү төөнө заслын бусад аргууд (гарын зүү, чихний зүү, толгойн зүү засал)
7. Даран бариа засал
8. Зонхилон тохиолдох халдварт бус өвчний зүү эмчилгээ
9. Хятад анагаах ухааны дотрын эмгэгүүдийн зүү эмчилгээ
10. Хятад анагаах ухааны мэдрэлийн эмгэгүүдийн зүү эмчилгээ
11. Хятад анагаах ухааны хүүхдийн өвчний зүү эмчилгээ
12. Хятад анагаах ухааны эмэгтэйчүүдийн өвчний зүү эмчилгээ
13. Хятад анагаах ухааны сэргээн засах эмчилгээ
14. Урьдчилан сэргийлэх анагаахын тойролт гэсэн 14 тойролтоор явуулна.

Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлага, Амилуулах суурь тусламж, Халдварын сэргийлэлт, хяналтын сургалтад заавал хамрагдана.

- Сургалтын нийт хугацаа 2 жил байна
- Тойролтын хугацааг үндсэн болон бусад сүлжээ эмнэлгүүдийн уламжлалтын тасгийн онцлог, хүчин чадалд тохируулан зохицуулна
- Суралцагч эмчийн өдөр тутмын болон 7 хоногийн үйл ажиллагааны хуваарийг сургалт эрхлэх эмнэлэг болон бусад сүлжээ эмнэлгүүдийн уламжлалт анагаах ухааны тасаг, сургалтын алба боловсруулна
- “Зүү эмчилгээ судлал” үндсэн мэргэшлийн сургалтыг сургалт эрхлэх зөвшөөрөл бүхий эмнэлгийн тусламжийн байгууллага эмнэлгүүдтэй сүлжээ үүсгэн хамтран ажиллана.

## **5.2 Зайлшгүй танин мэдэж, суралцах шаардлагатай шинж тэмдэг, өвчин, гардан үйлдэл:**

Сургалтын төгсгөлд орон нутагт ганцаараа бие даан уламжлалтын тусламж, үйлчилгээ үзүүлж чадах түвшинд хүрэхийн тулд эмнэл зүйн сургагч багшийн хяналт дор амбулаториор ирэх үйлчлүүлэгч, хэвтэн эмчлүүлэх үйлчлүүлэгчдийн уламжлалт анагаах ухааны оношилгоо, зүү эмчилгээг хариуцан хийх явцдаа дараах шинж тэмдэг, өвчин, гардан үйлдлийг гүйцэтгэж, туршлага хуримтлуулна.

### **5.2.1 Шинж тэмдэг (аль ч тойролтод тохиолдох):**

Өвчний түүх, бодит үзлэгт үндэслэн эрэмбэлэн ангилж, ялган оношилгоо хийн, анхан шатны эмчилгээ, уламжлалт анагаахын тусламж үйлчилгээг зүү эмчилгээтэй хослуулан үзүүлж чаддаг болох:

1. Халуурах (*Fever*)
2. Арьс, салс шарлах (*Jaundice*)
3. Толгой өвдөх (*Headache*)
4. Амьсгал давчдах (*Breathlessness*)
5. Багтрах (*Asthma*)
6. Толгой эргэх (*Dizziness*)
7. Ухаан алдах (*Altered level of consciousness*)
8. Таталт өгөх (*Seizure*)
9. Ханиалгах, цэр гарах (*Coughing, Excretion sputum*)
10. Цээжээр өвдөх (*Chest pain*)
11. Зүрх дэлсэх (*Palpitation*)
12. Дотор муухайрах, бөөлжих (*Nausea, Vomiting*)
13. Аманд гашуун амт амтагдах (*Bitter taste in the mouth*)
14. Хэвлийгээр өвдөх (*Abdominal pain*)
15. Аюулхайгаар өвдөх (*Epigastric pain*)
16. Суулгах (*Diarrhea*)
17. Баас хатах (*Constipation*)
18. Хоолны дуршил муудах (*Loss of appetite*)
19. Нуруугаар өвдөх (*Back pain*)
20. Булчин саажих (*Paralysis*)
21. Үеэр өвдөх (*Arthralgia*)
22. Чих шуугих (*Tinnitus*)
23. Нус хайрах (*Nasal discharge*)
24. Сэтгэл санаа тогтворгүй болох / дүүрэн, хоосон/ (*Mental instability*)

25. Нойр хулжих (*Insomnia*)
26. Хөлрөх / дүүрэн, хоосон/ (*Sweating*)
27. Өвдөх / дүүрэн, хоосон/ (*Pain*)
28. Хавагнах (*Oedema*)
29. Шээсний гарц өөрчлөгдөх (*Dysuria*)
30. Шээхэд өвдөх (*Painful urination*)

### 5.2.2 Өвчин:

- Өвчин тус бүрийг оношилж, эмчлэх, тусламж үзүүлж чаддаг болох
- Тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад орон нутгийн эмнэлгээс дээд шатлалын эмнэлэгт өвчтөн шилжүүлэх заалтыг мэддэг болох
- Дээд шатлалын эмнэлэгт өвчтөнийг аюулгүйгээр шилжүүлэх аргад суралцах
- Өвчтөн болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, төрөл садны хүнд орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг эрт үед нь илрүүлэх талаар зааж, зөвлөгөө өгөхөд суралцах

**Зайлшгүй суралцаж, таньж мэдэх шаардлагатай өвчин эмгэгүүд:**

**Гурван гэм, хурмал өвчин судлал**

1. Хийн өвчин (A00-A03)
2. Шарын өвчин (TMB00-TMB02)
3. Бадганы өвчин (TMC00-TMC03)
4. Хурмал борын өвчин (TMD00-TMD04)

**Дотор өвчин судлал**

5. Эс шингэх өвчин (TME00)
6. Бэтэг (TME01)
7. Цайвар хаван (TME02)
8. Суваг хаван (TME03)
9. Усан хаван (TME04)
10. Хорхойн өвчин (TME05)
11. Өтгөн хаагдах (TME06)
12. Шээс хаагдах (TME07)
13. Шижин (TME08)
14. Зүрхний өвчин (TMK00)
15. Уушгины өвчин (TMK01)
16. Элэгний өвчин (TMK02)
17. Дэлүүний өвчин (TMK03)
18. Бөөрний өвчин (TMK04)
19. Ходоодны өвчин (TMK05)
20. Нарийн гэдэсний өвчин (TMK06)
21. Бүдүүн гэдэсний өвчин (TMK07)
22. Цөсний өвчин (TMK08)

**Халуун өвчин судлал (TMF00-I00)**

23. Халуун, хүйтний хэрэгт товчоон (TMF00)
24. Уул талын завсрын халуун (TMF01)

25. Эс боловсорсон халуун (TMG00)
26. Дэлгэрсэн халуун (TMG01)
27. Хоосорсон халуун (TMG02)
28. Нуугдсан халуун (TMG03)
29. Хуучин халуун (TMG04)
30. Булингартсан халуун (TMG05)
31. Гэмтсэн халуун (TMH00)
32. Хямарсан халуун (TMH01)
33. Халдварт халуун (TMH02)

#### **Лаборатори**

34. Лабораторийн шинжилгээ
35. Зүрхний цахилгаан бичлэг, Дотор өвчин судлал
36. Хэт авиан оношилгоо (ЭХО)
37. Гэрлийн шинжилгээ (Рентген)

#### **Яаралтай тусламж судлал:**

38. Толгой, хүзүү, нурууны гэмтэл (суурь тусламж, тээвэрлэлт)
39. Түлэгдэл, хөлдөлт
40. Амьсгалын замд гаднын биетээр бөглөрөх, живэх
41. Ясны хугарал
42. Тархинд цус харвах (цочмог үеийн)
43. Зүрхний дутагдал, зүрхний шигдээс (цочмог үеийн)
44. Шок, Ком
45. Хүчил шүлтийн тэнцвэр алдагдал
46. Цочмог хордлого
47. Могой, шавжид хатгуулах (хачиг)

#### **5.2.3 Гардан үйлдэл**

1. Үндсэн сувгуудын сүв тодорхойлж нэмж, хасах аргаар хатгалт хийх
2. Сувгийн гаднах сүвүүдийг тодорхойлох, хатгалт хийх
3. Зонхилон тохиолдох эмгэгүүдийн үеийн зүү эмчилгээ хийх
4. Цахилгаан зүү эмчилгээ хийх
5. Чихний зүү эмчилгээ хийх
6. Гарын зүү эмчилгээ хийх
7. Хуйхны зүү эмчилгээ хийх
8. Арьсны зүү эмчилгээ хийх
9. Бичил хануур хийх
10. Соруул засал хийх
11. Самнуур хийх
12. Шууд, дам утаат болон утаан бус төөнө эмчилгээ хийх
13. Цахилгаан төөнө эмчилгээ хийх
14. Толгой, мөчид, их биеийн даран бариа хийх



## ТОЙРОЛТЫН АГУУЛГА

Сургалт нийт 88 долоо хоног үргэлжлэх тойролтуудыг хийж гүйцэтгэсэн байна. Тойролтоор сургалт хариуцсан байгууллагын координатор багш, сургагч багш, мэргэжилтнүүд хариуцан зохион байгуулж үр дүнг сургалтын дэвтэрт (log book) тэмдэглэнэ.

### Тойролтын хуваарь

д/д	Тойролтын сэдэв	Хугацаа /долоо хоногоор/
1	Зүү төөнө заслын онол арга зүйн тойролт	5
2	Зүүний сүвийн хэмжил зүй	6
3	Зүү төөнө заслын оношилгоо	8
4	Зүү төөнө заслын аргууд	5
5	Зүү төөнө заслын эмгэг зүй	6
6	Зүү төөнө заслын бусад аргууд (гарын зүү, чихний зүү, толгойн зүү засал)	6
7	Даран бариа засал	4
8	Зонхилон тохиолдох халдварт бус өвчний зүү эмчилгээ	18
9	ХАУ дотрын эмгэгүүдийн зүү эмчилгээ	6
10	ХАУ мэдрэлийн эмгэгүүдийн зүү эмчилгээ	6
11	ХАУ хүүхдийн өвчний зүү эмчилгээ	4
12	ХАУ эмэгтэйчүүдийн өвчний зүү эмчилгээ	4
13	ХАУ сэргээн засах эмчилгээ	5
14	Урьдчилан сэргийлэх анагаахын тойролт	5
	Нийт	88

### Эмнэлзүйн тойролт – 1. Зүү төөнө заслын онол арга зүй

Хятад эмнэлгийн онолуудыг судалж эрүүл бие махбодын бүтэц үйл ажиллагаа, өвчний үеийн биед гарах өөрчлөлт, эмгэг жам, оношилгоо, эмчилгээнд хэрэглэх зарчмыг судална.

- Зүү төөнө эмчилгээний хөгжлийн түүх
- Хүний биеийн цогц байдлын онол
- Арга билгийн онол
- Таван махбодын онол
- Цул, сав эрхтнүүдийн онол
- Хий, цус, биеийн шингэний онол
- Суваг хэрдсийн онол
- Өвчин үүсгэгч хүчин зүйлс
- Зүү эмчилгээний үндсэн онолуудыг эмнэлзүйтэй холбож, өвчин эмгэг үүсэх шалтгаан, түүний үед илрэх шинж тэмдгүүдийг тайлбарлах

- Зүү төөнө эмчилгээний онцлог, хүний бие махбодыг цогц байдлаар авч үзэх хандлага, анагаах ухааны деонтологийн асуудлууд, эмчийн ёс зүй, үүрэг хариуцлагын талаар суралцана

### **Эмнэлзүйн тойролт – 2. Зүүний сүвийн хэмжил зүй**

Зүү төөнө заслын үндсэн 12 суваг, (Эмнэлзүйн тойролт - 1)

Өврийн гол суваг, Арын гол сувгийн 365 сүв, зонхилон хэрэглэдэг сувгийн гаднах сүвийн байршил, морфологийн онцлог, эмчилгээний заалт, сүвийн онцлогийг судалж, байршлыг тодорхойлж сурна. Сүвийн онцлогт үндэслэн эмчилгээнд хэрэглэх үндсэн зарчмуудыг эзэмшинэ.

- Биеийн анатоми, харьцаат цунгийн хэмжилт
- ДЭМБ-аас гаргасан Зүүний сүвүүдийн байршлын Олон Улсын стандартчилал, 1989
- ДЭМБ-аас гарсан НДБЭБТ-оос гаргасан зүү төөнө заслын сүвийн хэмжилзүйн стандарт, 2012
- Хос 12 суваг, Дан сувгуудын сүвийн байршил
- Зүүний сүвүүдийн ангилал, онцлог
- Зүүний сүвүүдийн заалт (ерөнхий, онцгой)
- Хатгах, төөнөх хориотой сүвүүд
- Сувгийн гадна байрлалтай сүвүүд
- Зүү эмчилгээний жор найруулах зарчим, онцгой сүвүүдийг эмчилгээнд хэрэглэх зарчим
- Зүү эмчилгээний аюулгүй байдал, эрсдэлээс сэргийлэх
- Зүү эмчилгээний халдвар хамгаалал
- Эмнэлгийн ажилтны халдвар хамгаалал, эрүүл ахуй
- Эмнэлгийн орчны ариутгал, эмчилгээнд бэлтгэх нь
- Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ариутгал
- Зүүний сүвүүдийг хатгах, бусад эмчилгээ хийх аргыг эзэмшинэ
- Сүвүүдийн онцлог, заалт, байршлаас хамааран хүний бие махбод болон өвчин эмгэгийн онцлогт тааруулан зүү эмчилгээний “жор” найруулах
- Хүний биеийн гадаргууд байрлах сүвийг тодорхойлж зүүг хатгахдаа өвчтөнийг зөв байрлуулж, боловсон харьцаж, хийх гэж буй үйлдлийг, зүү хатгалтын үед үүсэж болохуйц хүндрэлүүдийн талаар тайлбарлах, эмчлүүлэгчийн тав тухыг алдагдуулахгүй, өвдөлт, эвгүйрэл үүсгэхгүй байх
- Эмчилгээний орчныг зөв бүрдүүлэхэд суралцана

### **Эмнэлзүйн тойролт – 3. Зүү төөнө заслын оношилгоо**

Өвчин үүсгэгч хүчин зүйлс (гадаад, дотоод, бусад), эмгэг үүсэх шалтгаан, эмгэг жам, оношилгооны аргууд (4 арга, 8 зарчим), өвчний эмгэг хам шинжүүдийн ялган оношилгоо: гадна дотор; халуун хүйтэн; дүүрэн хоосон; арга билиг; цусны хямралын эмгэг жам, цэр чийг булинггар үүсэх эмгэг жам, дотор эрхтний эмгэг хам шинжүүд; суваг хэрдэсний эмгэг хам шинжүүд; зургаан сувгийн эмгэг хам шинж.

- Өвчин үүсгэх хүчин зүйлс

- Эмгэг жам
- Оношилгооны 4 арга (Хятад анагаах ухааны оношилгооны аргуудыг эзэмшиж харах, сонсох, асуух, тэмтрэх аргаар эмчлүүлэгчээс асуумж авч, бодит үзлэг хийх)
- Оношилгооны 8 зарчим (гадна дотор; халуун хүйтэн; дүүрэн хоосон; арга билиг)
- Хий цус, биеийн шингэний эмгэг хам шинжүүд
- Цул, сав эрхтнүүдийн эмгэг хам шинжүүд
- Эмгэг хам шинжийг суваг хэрдэсний онолын зарчмаар ялган оношлох
- Шаардлагатай тохиолдолд орчин үеийн анагаах ухааны эмнэлзүйн үзлэг оношилгоог хийж Хятад анагаах ухааны оношийг орчин үеийн анагаах ухааны оноштой харьцуулах
- Бодит үзлэгээр олсон мэдээлэлд дүн шинжилгээ хийж бие махбодод үүссэн эмгэг, илэрч буй шинж тэмдгүүдийг уялдуулан тайлбарлах
- Шаардлагатай тохиолдолд мэргэжил нэгтэнтэй хамтарч оношилгоо, эмчилгээний төлөвлөгөө гаргах, бусад салбарын мэргэжилтнүүдтэй багаар ажиллаж сурна

#### **Эмнэлзүйн тойролт – 4. Зүү төөнө заслын аргууд**

*Зүү төөнө эмчилгээний техник ажиллагаа, хатгах төөнөх аргын онол, зүүний мэдрэмж, нарийн зүүг хатгах арга, зүү эмчилгээний нэмэх ба хасах арга, зүү хатгах эсрэг заалт болон анхаарах зүйлүүд, зүү хатгахад баримтлах аюулгүй ажиллагааны дүрэм, гарах хүндрэлийн үед авах арга хэмжээ, халдвар хамгаалалт; чихний зүү, гар, толгойн зүүг хатгах арга, гурвалжин зүүний эмчилгээ, арьсны зүү, арьсан доорх зүү, цахилгаан зүү, сүвд эмт бодис тарих арга; соруул засал, төөнө эмчилгээ хийх аргууд.*

- Зүү хатгах аргууд (нэмэх, хасах, тэгш аргууд)
- Дам болон шууд төөнө эмчилгээ хийх аргууд
- Зүү эмчилгээний хүндрэлүүдийн үед авах арга хэмжээ
- Зүү заслын бусад аргууд (жишээ нь: бага хануур, цахилгаан зүү эмчилгээ, арьсны зүү)
- Бумба эмчилгээ хийх аргууд
- Зүү эмчилгээг чиглүүлэгчтэй болон чиглүүлэгчгүй хатгах аргуудыг эзэмших
- Зүү эмчилгээний бусад аргуудаар эмчилгээ хийх
- Зүү эмчилгээний арга тус бүрийн үед гарч болох хүндрэлүүдээс урьдчилан сэргийлэх, хүндрэл гарсан тохиолдолд арга хэмжээ авч сурна

#### **Эмнэлзүйн тойролт – 5. Зүү төөнө заслын эмгэгзүй**

- *Хятад анагаах ухааны онолд үндэслэн өвчин үүсэх эмгэг жамыг тогтоон бие махбодод үүсэх эмгэг хам шинжүүдийг илрүүлэн ялгавартай оношилж, эмчилгээний зарчим тодорхойлох*

- ХАУ-ны үндсэн онол, өвчин үүсгэх шалтгаанд үндэслэн бие махбодын үндсэн 8 хам шинжийн ялгаа (дүүрэн-хоосон, халуун-хүйтэн, гадна-дотоно, арга-билиг)
- Цул, сав эрхтнүүдийн эмгэг хам шинжүүд
- Эрчим хүч, цус, биеийн шингэний эмгэг хам шинжүүд
- Bi-хам шинж, илрэх шинж тэмдгүүд, эмчилгээний зарчим
- Feng-хам шинж, илрэх шинж тэмдэг, эмчилгээний зарчим
- Wei-хам шинж, илрэх шинж тэмдгүүд, эмчилгээний зарчим
- Хорт хүйтний улмаас үүсэх эмгэг, илрэх шинжүүд, эмчилгээний зарчим
- Хорт чийг салстын улмаас үүсэх эмгэг, илрэх шинжүүд, эмчилгээний зарчим
- Хорт халууны улмаас үүсэх эмгэг, илрэх шинжүүд, эмчилгээний зарчим
- Хавсарсан болон оношлоход төвөгтэй хам шинжүүд, илрэх шинж тэмдэг, ялгах оношилгоо, эмчилгээний зарчим

### **Эмнэлзүйн тойролт – 6. Зүү төөнө заслын бусад аргууд**

*Зүү төөнө заслын бичил зүү эмчилгээний онол, оношилгоо, сүвүүдийн байршил зүй, заалт, эсрэг заалт, эмчилгээний зарчмуудыг судлах.*

- Чихний зүү эмчилгээ: чихний бүсүүд (зон), сүвүүдийн байршил зүй, заалт, эсрэг заалт, сүвээр оношлох арга, зүү хатгах арга, эмчилгээний улмаас гарч болох хүндрэлүүд
- Толгойны зүү эмчилгээ: толгойны бүсүүд (зон), сүвүүдийн байршил зүй, заалт, эсрэг заалт, зүү хатгах арга, эмчилгээний улмаас гарч болох хүндрэлүүд
- Гарын зүү эмчилгээ: гарт байрлах суваг, сүвүүдийн байршил зүй, заалт, эсрэг заалт, зүү хатгах арга, эмчилгээний улмаас гарч болох хүндрэлүүд
- Чихний сүвүүдийг тодорхойлох, стандартын дагуу хатгалт хийх, цахилгаан аппаратаар оношлох, эмчилгээнд хэрэглэх
- Толгойн бүсүүдийг тодорхойлох, хатгалт хийх арга барилыг эзэмших, эмчилгээнд хэрэглэх
- Гарын зүү эмчилгээний 12 хос болон 2 хос бус сувгийн байршлыг тодорхойлох, гарын зүүний сүвүүдийн тодорхойлж хатгалт хийх, жор найруулах, бусад зүү эмчилгээний аргуудтай хослуулах

### **Эмнэлзүйн тойролт – 7. Даран бариа засал**

*Бариа засал, ангилал, бариа хийх арга техник, бүх биеийн зөөлөн бариа засал, зонхилон тохиолдох өвчнүүдийн үед хийгдэх даран бариа заслыг судлах*

- Даран барианы үүсэл, хөгжил, ангилал, тохирох, цээрлэх өвчин, эмчилгээний үйлдэл
- Бариа хийх аргууд
- Бүх биеийн зөөлөн бариа хийх үндсэн арга техник
- Зонхилон тохиолдох эмгэгүүдийн даран бариа засал
- Эмчлүүлэгчийн байдалд дүн шинжилгээ өгч, онош тавьж, даран бариа заслыг стандартын дагуу хийх, гарын хүчийг тохируулж сурах

- Бариа заслын үед үүсэж болох хүндрэлээс урьдчилан сэргийлэх
- Эмчилгээ хийх явцад эмчлүүлэгчтэй зөв боловсон харьцаж, тайвшруулах, таатай нөхцөл бүрдүүлэх

### **Эмнэлзүйн тойролт – 8. Зонхилон тохиолдох халдварт бус өвчний зүү эмчилгээ**

*Зүү эмчилгээний үндсэн зарчим, зүү эмчилгээний өрөөний зохион байгуулалт, зүү эмчилгээний жорыг сонгох, онцгой сүвийг эмчилгээнд хэрэглэх зарчим, зонхилон тохиолдох эмгэгүүдийн үед хийх зүү эмчилгээний аргуудыг судлах*

- Зонхилон тохиолдох эмгэгүүдийн шалтгаан, хам шинжүүд, илрэх шинж тэмдгүүд, эмчилгээний зарчим, үндсэн болон нэмэлт жор, хатгалт хийх арга
- Өвчний явц, тавилан
- Яаралтай тусламжийн тохиолдлууд, авах арга хэмжээ
- Хувь хүнд зохимжтой эмчилгээний арга сонгох зарчим
- Эмчлүүлэгчийн байдалд дүн шинжилгээ өгч, онош тавьж, эмчилгээний төлөвлөгөө боловсруулах, зүү эмчилгээг стандартын дагуу хийх
- Зүү эмчилгээний үед үүсэж болох хүндрэлээс урьдчилан сэргийлэх
- Эмчилгээ хийх явцад эмчлүүлэгчтэй зөв боловсон харьцаж, зөв байрлуулж тайвшруулах, таатай нөхцөл бүрдүүлэх

### **Эмнэлзүйн тойролт – 9. Хятад анагаах ухааны дотрын эмгэгүүдийн зүү эмчилгээ**

*Дотор өвчнүүдийн оношилгоо эмчилгээг ХАУ-ны онол эмнэлзүйгээр тайлбарлаж орчин үеийн анагаах ухааны оношилгоо эмчилгээтэй хавсруулан өвчтөний эмчилгээний төлөвлөгөөг боловсруулж зүү эмчилгээг бусад эмчилгээний аргуудтай хослуулан хийж сурах.*

- Хятад анагаах ухааны дотор өвчнүүдийн оношилгоо зүү эмчилгээний талаар мэргэжлийн түвшний мэдлэгтэй болох
- Орчин үеийн анагаах ухааны дотрын өвчин судлалын талаар ерөнхий мэргэжлийн түвшинд мэдлэгтэй болох
- Дотрын өвчний зүү эмчилгээг орчин үеийн анагаах ухааны аргуудтай хослуулан хэрэглэх зарчмыг судлах
- Эмчлүүлэгчийн байдалд дүн шинжилгээ өгч, онош тавьж, эмчилгээний төлөвлөгөөг боловсруулах
- Эмчлүүлэгчийн хийсэн оношилгооны сорилуудыг тайлбарлаж эмнэлзүйн байдалтай харьцуулан онош тодруулах
- ХАУ-ны онолын дагуу эмнэлзүйн шинж тэмдэг болон хам шинжийг үндэслэн онош тавьж зүү эмчилгээний зарчим, жорыг боловсруулах
- Шаардлагатай үед орчин үеийн анагаах ухааны эмчилгээний аргуудтай хавсруулан эмчилгээ хийх арга барилтай болох
- Зүү эмчилгээний үед үүсэж болох хүндрэлээс урьдчилан сэргийлэх
- Эмчилгээ хийх явцад эмчлүүлэгчтэй зөв боловсон харьцаж, тайвшруулах, таатай нөхцөл бүрдүүлэх

## **Эмнэлзүйн тойролт – 10. Хятадын анагаах ухааны мэдрэлийн эмгэгүүдийн зүү эмчилгээ**

*Мэдрэлийн өвчнүүдийн үеийн эмгэг жамыг зүү эмчилгээний онол эмнэлзүйгээр тайлбарлаж, орчин үеийн анагаах ухааны оношилгоо эмчилгээний аргуудыг зохистой хэрэглэж, зүү эмчилгээг нэгдмэл байдлаар бусад аргуудтай хослуулан хийж сурах.*

- Мэдрэл судлалын үзлэг, оношилгооны аргуудад суралцах
- Мэдрэлийн зонхилон тохиолдох эмгэгүүдийн морфологи, физиологийн онцлог, эмгэг жам, илрэх шинж тэмдэг, эмчилгээний зарчмуудыг судлах
- Мэдрэлийн эмгэгүүдийн зүү эмчилгээний зарчим, хийх арга барилд суралцах
- Эмчлүүлэгчийн байдалд дүн шинжилгээ өгч, онош тавьж, эмчилгээний төлөвлөгөөг боловсруулах
- Эмчлүүлэгчид хийсэн үзлэг болон оношилгооны сорилуудыг үндэслэн эмгэгийг тайлбарлаж онош тодруулах
- Хятад анагаах ухааны онолын дагуу эмнэлзүйн шинж тэмдэг болон хам шинжийг үндэслэн зүү эмчилгээний зарчим, жорыг боловсруулах
- Шаардлагатай үед орчин үеийн анагаах ухааны эмчилгээний аргуудтай хавсран эмчилгээ хийх арга барилтай болох
- Зүү эмчилгээний үед үүсэж болох хүндрэлээс урьдчилан сэргийлэх
- Эмчилгээ хийх явцад эмчлүүлэгчтэй зөв боловсон харьцаж, тайвшруулах, таатай нөхцөл бүрдүүлэх

## **Эмнэлзүйн тойролт – 11. Хятадын анагаах ухааны хүүхдийн өвчний зүү эмчилгээ**

*Зонхилон тохиолдох хүүхдийн өвчнүүдийн оношилгоо эмчилгээг ХАУ-ны онол эмнэлзүйгээр тайлбарлаж орчин үеийн анагаах ухааны оношилгоо эмчилгээтэй хавсруулж өвчтөний эмчилгээний төлөвлөгөөг боловсруулан зүү эмчилгээг бусад эмчилгээний аргуудтай хослуулан хийж сурах*

- Хүүхдийн биеийн физиологийн онцлогууд, хүүхдэд үзлэг хийх арга
- Хүүхдийн зонхилон тохиолдох эмгэгүүдийн оношилгоо эмчилгээний аргууд
- Хятад анагаах ухаанд хүүхдийн өвчний шалтгаан, эмгэг жам, оношилгоо, эмчилгээний зарчим тайлбарлах онцлог
- Хүүхдийн өвчин эмгэгийн үед хийх зүү эмчилгээ, орчин үеийн анагаах ухаантай хослуулах арга зам
- Хүүхдийн биеийн байдалд дүн шинжилгээ хийж, онош тодруулан, эмчилгээний төлөвлөгөөг боловсруулах
- Хүүхдийн эцэг эхтэй боловсон зөв харьцах, хүүхдийн биеийн байдлыг тайлбарлах
- Хятад анагаах ухааны аргаар хүүхдэд үзлэг хийх, эмгэг хам шинжийг тайлбарлах, эмчилгээний зарчим боловсруулах

- Хүүхэд болон түүний эцэг эхэд эмчилгээний таатай нөхцөл бүрдүүлэх
- Эмчилгээ хийхээс өмнө хүүхдийг тайвшруулж, саатуулах
- Хүүхдэд зүү эмчилгээний үед үүсэж болох хүндрэлээс урьдчилан сэргийлэх

### **Эмнэлзүйн тойролт – 12. Хятадын анагаах ухааны Эмэгтэйчүүдийн өвчний зүү эмчилгээ**

*Эмэгтэйчүүдийн эмгэгийн оношилгоо эмчилгээг Хятад анагаах ухааны онол, эмнэлзүйгээр тайлбарлаж орчин үеийн анагаах ухааны оношилгоо эмчилгээтэй хавсруулан эмчилгээний төлөвлөгөөг боловсруулж зүү эмчилгээг бусад эмчилгээний аргуудтай хослуулан хийж сурах.*

- Эмэгтэйчүүдийн зонхилон тохиолдох эмгэгүүдийн талаар ерөнхий мэргэжлийн эмчийн түвшинд мэдлэгтэй болох
- Хятад анагаах ухааны онолоор эмэгтэйчүүдийн эмгэг үүсгэх шалтгаан, хам шинж, илрэх шинж тэмдгүүд, эмчилгээний зарчим тайлбарлах, зүү эмчилгээний үндсэн болон нэмэлт жор боловсруулах, зүү хатгах
- Эмэгтэйчүүдийн зонхилон тохиолдох эмгэгүүдийн эмчилгээг зүү эмчилгээтэй хослуулах аргуудыг сонгох
- Эмчлүүлэгчийн байдалд дүн шинжилгээ өгч, онош тавьж, эмчилгээний төлөвлөгөөг боловсруулах
- Эмэгтэйчүүдийн үзлэг хийж, анхан шатны шинжилгээг авах
- Эмчлүүлэгчид хийсэн оношилгооны сорилуудыг тайлбарлаж эмнэлзүйн байдалтай харьцуулан онош тодруулах
- Эмэгтэйчүүдийн үзлэг болон эмчилгээ хийхэд таатай нөхцөл бүрдүүлэх
- Зүү эмчилгээний үед үүсэж болох хүндрэлээс урьдчилан сэргийлэх
- Эмчилгээ хийх явцад эмчлүүлэгчтэй зөв боловсон харьцаж, тайвшруулах, таатай нөхцөл бүрдүүлэх

### **Эмнэлзүйн тойролт – 13. Хятадын анагаах ухааны сэргээн засах эмчилгээ**

*Сэргээн засах анагаах ухааны суурь мэдлэгтэй болж, Хятад анагаах ухааны сэргээн засах эмчилгээний аргуудтай хослуулан эмчлүүлэгчийн болон түүний ар гэрийнхний амьдралын чанар, нийгэмд эзлэх байр суурийг сайжруулахад чиглэсэн мэдлэг чадвар хандлагатай болно.*

- Өвчний улмаас үүсэх хөдөлмөрийн, нийгмийн, өдөр тутмын амьдралын чадвар алдагдах шалтгаан, илрэх шинж тэмдгүүд, оношилгоо, эмчилгээний онцлогууд
- Амьдралын, нийгмийн, хөдөлмөрийн чадвар алдагдлын ХАУ-ны оношилгоо, эмгэгзүй, түүний зүү эмчилгээний онцлог, зарчим, үндсэн ба нэмэлт жор
- Өвдөлт намдаах, хөдөлгөөн болон бусад үйл ажиллагаа сэргээх эмчилгээний зарчмууд

- Эмчлүүлэгчийн байдалд дүн шинжилгээ өгч, онош тавьж, эмчилгээний төлөвлөгөөг боловсруулах
- Сэргээн засах эмчилгээний аргуудыг хэрэглэн эмчлүүлэгч болон ар гэрийнхэнд хийх эмчилгээг зааж өгөх мэдлэг, чадвар, хандлагатай болох
- Эмчлүүлэгчийн хийсэн оношилгооны сорилуудыг тайлбарлаж эмнэлзүйн байдалтай харьцуулан нөхөн сэргээх эмчилгээний зарчим боловсруулах
- ХАУ-ны онолын дагуу эмнэлзүйн шинж тэмдэг болон хам шинжийг үндэслэн онош тавьж сэргээн засах зүү эмчилгээний зарчим, жорыг боловсруулах
- Шаардлагатай үед орчин үеийн анагаах ухааны эмчилгээний аргуудтай хавсруулан эмчилгээ хийх арга барилтай болох
- Сэргээн засах эмчилгээ хийх таатай нөхцөл бүрдүүлэх
- Зүү эмчилгээний үед үүсэж болох хүндрэлээс урьдчилан сэргийлэх чадамж эзэмшинэ

#### **Эмнэлзүйн тойролт – 14. Өвчнөөс урьдчилан сэргийлэх анагаах ухаан**

*Зорилт: Өвчнөөс урьдчилан сэргийлэх анагаах ухааны зарчмууд, Хятад анагаах ухааны өвчнөөс сэргийлэх ёс: биеийн эсэргүүцэл сайжруулж өвчнөөс сэргийлэх, үүссэн өвчний хүндрэлээс урьдчилан сэргийлэх, зүү эмчилгээний хүндрэлүүдээс урьдчилан сэргийлэх. Зүү эмчилгээг сэргээн засах анагаах ухааны эмчилгээний аргуудтай хослуулан хэрэглэх, амьдралын чанарыг сайжруулах зарчим.*

- Өвчнөөс урьдчилан сэргийлэх анагаах ухааны зарчмууд
- ХАУ-ны өвчнөөс урьдчилан сэргийлэх ёс (сэтгэлийн гэм, биеийн дасгал, идээ ундаа, явдал мөрийн зарчим)
- Өвчин хүндрэхээс урьдчилан сэргийлэх (эрт оношилгоо, өвчин үүсгэгч анхдагч шалтгаан тодорхойлох, бие махбодын тэнцвэр хангах)
- Өвчнөөс урьдчилан сэргийлэх анагаах ухааны зарчмуудыг эмчлүүлэгчдэд заах, хүн амын дунд эрүүл амьдрах зарчмуудын талаар сургалт зохион байгуулах
- Эмчлүүлэгчдэд өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг хүндрэхээс сэргийлэх талаар зөвлөгөө өгөх
- ХАУ-ны эх сурвалж болон орчин цагийн анагаах ухааны судалгаа шинжилгээний ажлуудыг үндэслэн өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчин хүндрэхээс сэргийлэх аргуудын талаар мэдлэгээ тогтмол дээшлүүлж байх

#### **Загвар 1.**

##### **Ажлын байрны сургалт (On-the-Job Training)**

Аргачлал	Суралцагч эмчийн тоо	Үргэлжлэх цаг, давтамж	Сургалт явагдах газар	Үйлчлүүлэгч/ Хэрэгдэхүүн	Удирдагч, хамтрагч
Амбулаторын үзлэг хийх	1	3 цаг 7 хоногт 2 удаа	Амбулатори	Өвчтөн	Эмнэлзүйн сургагч багш



Хяналтын тойрон үзлэг хийх	3-5	1 цаг Өдөр бүр	Тасаг	Өвчтөн	Эмнэлзүйн сургагч багш
Сургалтын тойрон үзлэг хийх	3-5 хүртэл	1 цаг 7 хоногт 1 удаа	Сургалтын өрөө, танхим	Слайд	Эмнэлзүйн сургагч багш
Гардан үйлдэл хийх	Өдөр бүр 3-5	Шаардагдах хугацаагаар	Эмчилгээний өрөө	Өвчтөн	Эмнэлзүйн сургагч багш

### Хяналтын тойрон үзлэг:

Хэвтэн эмчлүүлж байгаа эмчлүүлэгчийн биеийн байдлыг суралцагч эмч нь эмнэл зүйн сургагч багшид (бусад эмч) танилцуулах зорилготой үзлэг. Үүний тулд суралцагч эмч нь урьдчилан бие даан өвчний түүх, сувилагчийн тэмдэглэлийг үзэж танилцан, эмчлүүлэгчтэй уулзаж асуумж цуглуулж (ганцаарчилсан үзлэг), эмнэл зүйн сургагч багшид (бусад эмч) танилцуулахад бэлдэнэ. Танилцуулга хийхдээ хувь хүний мэдээллийг анхаарна. Танилцуулгыг сургалтын өрөө, танхим эсвэл өвчтөний өрөөнөөс гадна хийх ба өвчтөний орны дэргэдэх тойрон үзлэгийг эмнэл зүйн сургагч багштай (бусад эмч) хамт хийнэ. Хяналтын тойрон үзлэгээр өвчтөнөөс асуумж авах, үзлэг хийх аргад суралцана.

### Сургалтын тойрон үзлэг: тасагт, өөр эмчийн өвчтөн

Сургалтад тохиромжтой 1-2 өвчтөнийг сонгож, өвчтөний биеийн байдлыг суралцагч эмч нь танилцуулах ба бусад оролцогчид (хамтран суралцагч эмч, эмнэл зүйн сургагч багш, бусад эмч) асуулт тавьж, хэлэлцүүлэг өрнүүлнэ. 1 тохиолдолд 30-60 минут зарцуулна. Үүний дараа өвчтөний орны дэргэд үзлэг хийнэ. Хэлэлцүүлгийн явцад эмнэл зүйн таамаглал дэвшүүлэх, онош тавих зэрэгт суралцана.

## Загвар 2.

### Танхимын сургалт (*Off-the-Job Training*)

Аргачлал	Суралцагч эмчийн тоо	Үргэлжлэх цаг, давтамж	Сургалт явагдах газар	Хэрэгдэхүүн	Удирдагч, хамтрагч
Бие даалт	1	Тохиромжтой чөлөөт цаг	Гэртээ, номын сан	Ном, интернэт	Өөрөө, хамтран суралцагч эмч
Лекц	25 хүртэл	7 хоногт 2-3 удаа 90 минут	Сургалтын анги, танхим	Слайд	Эмнэлзүйн сургагч багш, хамтран суралцагч эмч
Журнал клуб	25 хүртэл	7 хоногт 1 удаа 60 минут	Сургалтын анги, танхим	Слайд, эрдэм шинжилгээний өгүүлэл	Эмнэлзүйн сургагч багш, хамтран суралцагч эмч
Симуляци (дуураймал орчин)	5 хүртэл	7 хоногт 1 удаа 60 минут	Ур чадварын өрөө, яаралтай тусламжийн өрөө	Хамтран суралцагч эмч, манекин	Эмнэлзүйн сургагч багш

## Үйл ажиллагааны хуваарь

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан
8:30-9:00	Ганцаарчилсан үзлэг	Ганцаарчилсан үзлэг	Ганцаарчилсан үзлэг	Ганцаарчилсан үзлэг	Ганцаарчилсан үзлэг
9:00-10:00	Хяналтын тойрон үзлэг	Хяналтын тойрон үзлэг	Хяналтын тойрон үзлэг	Хяналтын тойрон үзлэг	Хяналтын тойрон үзлэг
10:00-12:00	Лекц, семинар	Амбулаторийн үзлэг	Лекц, семинар		Амбулаторийн үзлэг
15:00-16:00		Амбулаторийн үзлэг		Журнал клуб	Амбулаторийн үзлэг
16:00-17:00	Симуляци (дуураймал орчин)		Сургалтын тойрон үзлэг		

## ДОЛОО. ҮНЭЛГЭЭ, ЭРГЭН ЗӨВЛӨГӨӨ

## 7.1 Суралцагч эмч ба хариуцагч

Сургалтын 2 жилийн хугацаанд суралцагч эмч бүрд хэрхэн ахин дэвшиж байгаа, хэрхэн сайжруулах тухай эргэн зөвлөгөө өгөх, суралцагч эмчийн хувийн төлөвлөгөөний талаар зөвлөлдөх, тэднийг хариуцан ажиллах хүн ((mentor) цаашид "хариуцагч" гэх)-ийг оноож хуваарилна. Суралцагч эмч нь сургалт эхлэх үед хариуцагчтай уулзах ба цаашид 2-3 сар тутамд 1 удаа уулзаж ярилцан, үнэлгээтэй танилцаж, эргэн зөвлөгөө авна.

## 7.2 Суралцагч эмч ба эмнэл зүйн сургагч багш

Суралцагч эмчийн тойролт бүрд сургалт удирдах эмнэл зүйн сургагч багш оноож хуваарилна:

- Суралцагч эмч нь тухайн тойролт эхлэхээс өмнө эмнэл зүйн сургагч багштай уулзаж, тойролтын хугацаанд тавьсан зорилтоо ярилцана.
- Суралцагч эмч нь тойролтын явцад тавьсан зорилтод хүрэхийн тулд дутагдаж байгаа зүйлийн тухай эмнэл зүйн сургагч багштай ярилцана.
- Суралцагч эмч нь тойролт дуусахад эмнэл зүйн сургагч багштай ярилцлага хийж, сургалттай холбоотой асуудлаар заавар, зөвлөгөө авна.
- Сургагч багш нь Анагаах ухааны магистр, доктор, дэд профессор, профессор цол зэргээс доошгүй зэрэгтэй, багшлах эрх бүхий, сурган заах арга зүйн албан ёсны сургалтад хамрагдсан байна.
- Сургагч багш нь мэргэжлийн ахлах, тэргүүлэх зэрэгтэй эмч, 8-аас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан, дадлага туршлагатай, сурган заах арга зүйн албан ёсны сургалтад хамрагдсан байна.
- Элсэгч нь Анагаах ухааны их, дээд сургуулийг Уламжлалт анагаах ухааны хүний их эмчийн мэргэжлээр төгссөн, бакалаврын зэрэгтэй байна.

## 7.3 Үнэлгээний арга

### 7.3.1 Төгсөлтийн шалгалт

"Зүү эмчилгээ судлал"-ын сургалтын төгсөлтийн шалгалтыг онолын ба гардан шалгалтаар авна. Шалгалтад тэнцсэн тохиолдолд Зүү эмчилгээний эмчийн үнэмлэх олгоно.

### 7.3.2 Ажлын байранд суурилсан үнэлгээ (*Workplace-based Assessment*)

#### **360 хэмийн үнэлгээ (*360-Degree Assessment*):**

Суралцагч эмчийн мэргэжлийн байх (*professionalism*) болон зохион байгуулагч, манлайлагч (*leader*) байх зэргийг үнэлэхэд хэрэглэнэ. 2 жилийн сургалтын дунд үе болон төгсөх үед хийнэ. Тойролтыг удирдсан эмнэл зүйн сургагч багш, сувилахуйн мэргэжилтэн, тухайн тасаг, нэгжийн хамтран ажилласан эмч, эмнэлгийн мэргэжилтэн, өвчтөн зэрэг нийт 5 хүн тус тусдаа үнэлнэ. Үнэлгээ хийх хүнийг сургалтын албанаас сонгоно. Үнэлгээний дүнг суралцагч эмч болон хариуцагчид танилцуулж, үнэлгээнд үндэслэсэн эргэн зөвлөгөөг хариуцагчаас суралцагчид өгнө.

#### **Mini-CEX/Эмнэл зүйн дасгал үнэлгээ (*Mini-Clinical Evaluation Exercise*):**

Зайлшгүй таньж мэдэх 30 шинж тэмдгээс тойролт бүрд 5-аас доошгүй шинж тэмдгийг түс бүр 3-аас доошгүй удаа, нийт 15-аас доошгүй удаа үнэлгээ хийнэ. Өөр тойролтод ижил шинж тэмдгээр үнэлгээ хийсэн ч болно. (Жишээ нь: Үндсэн зургаан өвчний тойролтод хэвлийгээр өвдөх шинж тэмдгийг оролцуулан 5 шинж тэмдгээр үнэлгээ хийсэн бол дотор өвчин, эс шингэсэн өвчний тойролтод ч хэвлийгээр өвдөх шинж тэмдгийг оролцуулан 5 шинж тэмдгээр үнэлгээ хийж болно).

Үнэлгээ хийх эмчийг эмнэл зүйн сургагч багш эсвэл тухайн тасаг, нэгжийн туршлагатай эмч нараас суралцагч эмч өөрөө сонгох ба тухайн сонгосон эмч шууд ажиглаж, үнэлгээ хийсний дараа үр дүнг суралцагч эмчид танилцуулж, цаашид хэрхэн сайжруулах зөвлөгөө заавал өгнө.

#### **Гардан үйлдлийн ур чадварын шууд ажиглалт / DOPS (*Direct Observation of Procedural Skills*):**

Зайлшгүй сурах 14 гардан үйлдлээс 10-аас доошгүйг хийж чаддаг болсныг эмнэл зүйн сургагч багш нотолж, баталгаа өгөх хүртэл давтан үнэлгээ хийнэ. Үнэлгээ хийх эмчийг эмнэл зүйн сургагч багш эсвэл тухайн тасаг, нэгжийн туршлагатай эмч нараас суралцагч эмч өөрөө сонгох ба тухайн сонгосон эмч шууд ажиглаж, үнэлгээ хийсний дараа үр дүнг суралцагч эмчид танилцуулж, цаашид хэрхэн сайжруулах зөвлөгөө заавал өгнө.

#### **Портфолио үнэлгээ (*Portfolio Assessment*):**

Суралцагч эмч нь сургалтын хугацаанд суралцсан лекц, уламжлалт анагаахын тусламж үйлчилгээний сургалтын үеэр эрүүл мэндийн сургалт,

сурталчилгаа хийсэн материал зэрэг сургалттай холбоотой бусад бичиг баримтыг үр дүн болгож хадгална.

#### **7.4 Үнэлгээний дүнг хянах**

- 360 хэмийн үнэлгээний дүнг сургалтын алба хяналт тавьж, хадгална. Үнэлгээний дүнг суралцагч эмч, хариуцагчид танилцуулах ба бусадтай хуваалцахгүй байхыг анхааруулна.
- Mini-CEX болон DOPS үнэлгээний дүнг суралцагч эмч өөрөө хадгална.
- Портфолиод үнэлгээ, эмнэл зүйн сургагч багштай зөвлөлдсөн бусад асуудал, өгсөн зөвлөгөөг бичиж тэмдэглэн хадгална.
- Суралцагч эмч нь тойролт бүрийн төгсгөлд Mini-сех болон DOPS үнэлгээний дүнг сургалтын албанд хүлээлгэн өгнө.
- Сургалтын алба үнэлгээний дүнг сургалтын хяналтын зөвлөлд танилцуулах ба сургалтын төгсгөлд хариуцагчаас суралцагч эмчид зөвлөгөө өгнө.

#### **7.5 Сургалтын төгсөлтийг шийдвэрлэх**

- Тойролт бүрд хийгдсэн Mini-сех болон DOPS үнэлгээний дүнг нэгтгэсний үндсэн дээр суралцагч эмчийг тухайн тойролтыг төгсгөх эсэх шийдвэрийг сургалтын хяналтын зөвлөл гаргана. Сургалтын хяналтын зөвлөл нь тойролт бүрт хийгдсэн Mini-сех болон DOPS үнэлгээний дүн, 360 хэмийн үнэлгээний нэгдсэн дүн, суралцагчийн сургалтын ирц, зайлшгүй таньж мэдэж суралцах шинж тэмдэг, өвчний тохиолдол, гардан үйлдлийн тоог харгалзан сургалтын төгсөлтийг эцсийн шийдвэрийг гаргана. Шийдвэр гаргах шалгуур нь:
- Зайлшгүй таньж мэдэх 30 шинж тэмдгээс 2 жилийн турш 25-оос доошгүйг оношилж, эмчлэн туршлага хуримтлуулсан байна. Зайлшгүй туршлага хуримтлуулсан байх шаардлагатай өвчний тохиолдлын тоо нь:
  - \* Тойролт бүрд заагдсан өвчний бүх тохиолдлыг тус бүр 5-аас доошгүй удаа үзэж, туршлага хуримтлуулсан байна.
  - \* Зайлшгүй суралцах 14 гардан үйлдлээс 2 жилийн турш 12-аас доошгүйг хийж гүйцэтгэн, туршлага хуримтлуулсан байна.
- Тойролт бүрийн төгсгөлд эсвэл 2 жилийн сургалтын эцэст суралцагчийг төгсгөх боломжгүй гэсэн шийдвэр гарсан тохиолдолд шалтгаан, цаашид сургалтыг хэрхэн төгсгөх талаарх шийдвэр, зөвлөмжийг сургалтын алба болон хариуцагчаас тухайн суралцагч эмчид тайлбарлаж өгнө.

### **НАЙМ. ХЭРЭГЖҮҮЛЭЛТ**

#### **(Хөтөлбөрийг нэвтрүүлэх ба хэрэгжүүлэх)**

#### **8.1 Сургалтын хяналтын зөвлөл**

- Сургалтын албаны мэргэжилтэн, эмнэлгийн тусламж, үйлчилгээний байгууллагын дэд дарга, амбулатори - уламжлалт эмчилгээний тасгийн хариуцагч, тухайн тойролтын сургалт хариуцагч, сувилахуйн албаны төлөөлөл, эмнэлгийн захиргааны албаны төлөөлөл, суралцагч эмчийн төлөөллөөс бүрдэнэ. Сургалтын хяналтын зөвлөл нь эмнэлгийн тусламж, үйлчилгээний байгууллагын даргын шууд удирдлага дор ажиллана.

- Сургалтын хяналтын зөвлөл нь сар бүр хуралдана.
- Сургалтын хяналтын зөвлөл нь суралцагч эмчийн сургалт, тулгарсан асуудалтай танилцах, суралцагч эмчтэй холбоотой бүх асуудлыг ярилцаж, шийдвэрлэх арга замыг судалдаг бүтэц байна.
- Сургалтын хяналтын зөвлөлийн гишүүд нь сургалтыг илүү сайжруулахын тулд өөрийн мэдлэг, боловсролоо дээшлүүлэхийг зорьж ажиллана.

## **8.2 Хөтөлбөрийн хяналт**

- Сургалтын алба хөтөлбөрт 5 жил тутамд үнэлгээ хийнэ.
- Хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалтын төлөвлөгөө гаргах, эмнэл зүйн сургагч багшид чиглэсэн сургалт (Faculty Development), суралцагч эмчийн нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх, шаардагдах санхүүжилтийг төсөвт тусгах зэргийг сургалтын алба хариуцна.

## **8.3 Сургалтын танилцуулга (*Orientation*)**

Сургалт эхлэхийн өмнө тойролт бүрийн сургалтын төлөвлөгөө (*Program*) болон хөтөлбөрийн (*Curriculum*) агуулгын уялдааг тодорхой ойлгох, сургалт эрхлэх байгууллага (эмнэлэг, эрүүл мэндийн төв), түүний үйл ажиллагаа, эмчилгээ, оношилгооны аюулгүй байдал, халдварын сэргийлэлт хяналт, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа, хандлага эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж буй хууль, журам, зөрчлийн тухай хууль, эмнэлгийн эрхзүйн тухай суралцагч эмчид гүнзгий ойлголт өгөх зорилго бүхий танилцуулга хичээлийг зохион байгуулна.

**360 ХЭМИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Суралцагч эмчийн нэр: \_\_\_\_\_

Үнэлгээ хийгч:  Эмнэл зүйн сургагч багш  Сувилагч  Бусад \_\_\_\_\_

Суралцагч эмчийг ажигласны үндсэн дээр, бусдаас сонссон, мэдсэн зүйл дээр бус, суралцагч эмчийн зан үйлийг хэр давтамжтай байсныг өөрийнхөө ажигласнаар оноо тавина уу.

<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Үнэлэх боломжгүй	Ховор (≤19)	Заримдаа (20-49%)	Ихэнхдээ (50-79%)	Бараг бүгд (≥80%)
Өвчтөн/гэр бүлийн хувийн асуудлыг хүндэтгэдэг	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3 <input type="checkbox"/> 4
Эмнэлгийн бичиг баримтыг бүрэн гүйцэт, гаргацтай, цаг хугацаанд нь хөтөлдөг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3 <input type="checkbox"/> 4
Орон нутгийн хүн амын эрүүл мэндийн асуудалд өөрийн санаачилгаар хувь нэмрээ оруулдаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3 <input type="checkbox"/> 4
Өвчтөний бие даасан байдлыг хүндэтгэж, өвчтөнд тохирсон хамгийн зөв шийдвэрийг гаргахад хичээн зүтгэл гаргадаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3 <input type="checkbox"/> 4
Хувь хүний онцлогийг харгалзан өвчтөнийг хүндэтгэж эмчилдэг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3 <input type="checkbox"/> 4
Өөрийн эмнэл зүйн ур чадварыг дээшлүүлэхийн тулд сургалт болон бусад боломжийг алдалгүй ашигладаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3 <input type="checkbox"/> 4
Өөрийн уламжлалт анагаах ухааны онолын мэдлэгээ дээшлүүлэхийн тулд бие даан суралцдаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3 <input type="checkbox"/> 4
Орон нутаг дахь бусад эмнэлгийн мэргэжилтэнтэй хамтран ажилладаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3 <input type="checkbox"/> 4
Эмнэлэг доторх бусад эмч, мэргэжилтэнтэй хамтран ажилладаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3 <input type="checkbox"/> 4
Орон нутгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зохион байгуулах, манлайлах үүрэгтэйг ухамсарладаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3 <input type="checkbox"/> 4
Эмнэлэг доторх тусламж, үйлчилгээнд зохион байгуулах, манлайлах үүрэгтэйгээ ухамсарладаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3 <input type="checkbox"/> 4

**1 эсвэл 4 оноо тавьсан бол тухайн асуултын дагуу саналаа бичнэ үү.**

--

**Дүгнэлтийг тодорхой бичих хэрэгтэй.** Жишээ нь: "Тэр бол найдваргүй" гэх нь тодорхой биш. Илүү хэрэг болох дүгнэлт бол: "Тэр сүүлийн 3 удаагийн журнал клубийн 2-т нь хэн нэгэнд урьдчилан мэдэгдэлгүйгээр оролцсонгүй."

**Өөрөөсөө асуу: "Миний дүгнэлт цаашид сайжрахад нь суралцагч эмчид хэрэг болох уу?"**

## ЯВЦЫН MINI-СЕХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Он,сар, өдөр \_\_\_\_\_/\_\_\_\_\_/\_\_\_\_\_

Суралцагч эмчийн нэр: \_\_\_\_\_

Үнэлэгчийн нэр: \_\_\_\_\_

Сургалт эрхлэх байгууллага: \_\_\_\_\_ Нэгж: \_\_\_\_\_ Газар:  Амбулатори  
 Эмийн үйлдвэр  УА тасаг  Бусад \_\_\_\_\_ Өвчтөний нас: \_\_\_\_\_ Хүйс:  Эр  Эм

Өвчтөний зовуурь:  Халуурах  Шарлах  Толгой өвдөх  Ухаан санааны байдал өөрчлөгдөх  Татах  Ханиалгах  Цээжээр өвдөх  Дотор муухайрах, бөөлжих, Хоосон огих  Хэвлийгээр өвдөх  Суулгах  Нуруу өвдөх  Саажих  Хавагнах  Үе өвдөх  Зүрх зогсох  Жихүүцэх  Эвшээх, суниах  Таван мэдрэхүй үл тодрох  Сэтгэл санаа тогтворгүй болох  Сүүж бэлхүүс, яс үесээр хатгуулж өвдөх  Энд тэндгүй тогтворгүй өвдөх  Идээ шингэсний дараа, өглөө үүрээр, үдшийн бүрийд өвчин хөдлөх  Аманд гашуун амт амтагдах  Идээ шингэх үед өвдөх  Хоолонд дургүй болох  Бусад

Сайн талууд	Сайжруулахад чиглэсэн зөвлөгөө	Бусад

Сургалтын тухайн үед суралцагч эмчийг ямар түвшинд байгааг ажигласнаа үнэлнэ үү.

Бодит үзлэг хийх шаардлагагүй тохиолдолд тэмдэглэнэ үү

Үнэлгээ	Хангалтгүй	Завсрын	Хангалттай
Өвчний түүх авах			
Бодит үзлэг			
Оношилгоо, эмчилгээний менежмент			
Харилцааны ур чадвар			
Эмнэл зүйн ерөнхий чадвар			

Сайжруулахын тулд зөвшилцөж биелүүлэх үйлдэл

--

Үнэлэгчийн гарын үсэг \_\_\_\_\_ Суралцагч эмчийн гарын үсэг \_\_\_\_\_

"Хангалттай" гэж тодорхойлоход хэрэглэх үзүүлэлт	
Өвчний түүх авах	<ul style="list-style-type: none"> <li>• ялган оношилгоо хийхүйц дэлгэрэнгүй асуумж авдаг</li> <li>• өвчтөний хэрэгцээг илрүүлж, хариу үзүүлдэг.</li> <li>• өвчтөний дохио зангааг ойлгож, тохиромжтой хариу үзүүлдэг.</li> </ul>
Бодит үзлэг	<ul style="list-style-type: none"> <li>• ялган оношилгоо хийхүйц дэс дараалсан бодит үзлэг хийдэг.</li> <li>• үзлэгийн үед өвчтөнд таатай байдал бүрдүүлэхэд анхаардаг.</li> </ul>
Эмнэл зүйн менежмент	<ul style="list-style-type: none"> <li>• зөв онош тавьдаг</li> <li>• оношилгоо, эмчилгээнд шаардлагатай шинжилгээ төлөвлөж, үр дүнг ашигладаг.</li> <li>• тохирсон эмчилгээг эхлүүлдэг.</li> <li>• тохирсон тасаг, эмнэлэгт шилжүүлдэг, цааш нь хяналт тавьдаг.</li> </ul>

Харилцааны ур чадвар	<ul style="list-style-type: none"> <li>• өвчтөн, түүний гэр бүл, асран хамгаалагч, төрөл садны хүнийг сайн сонсдог.</li> <li>• өвчтөн, түүний гэр бүл, амран хамгаалагч, төрөл садны хүнтэй эелдэг энгийн үг хэллэг хэрэглэж харилцдаг</li> <li>• өвчтөн, түүний гэр бүл, амран хамгаалагч, төрөл садны хүний зовнилыг хуваалцаж, хүндэтгэлтэй ханддаг.</li> </ul>
Эмнэл зүйн ерөнхий чадвар	<ul style="list-style-type: none"> <li>• Системтэй (харилцан уялдаатай) арга замыг тодорхойлдог.</li> <li>• өвчтөний таатай, аюулгүй байдлыг хангахад тодорхой идэвх зүтгэл гаргадаг</li> <li>• би гэр бүлийнхээ хэн нэгнийг энэ эмчээр эмчлүүлэхийг зөвшөөрч чадна!</li> </ul>

ХАВСРАЛТ 3

### ГАРДАН ҮЙЛДЛИЙН УР ЧАДВАРЫН ШУУД АЖИГЛАЛТ (DOPS)-ЫН ҮНЭЛГЭЭ

Он,сар, өдөр \_\_\_\_\_/\_\_\_\_\_/\_\_\_\_\_

Суралцагч эмчийн нэр: \_\_\_\_\_

Үнэлэгчийн нэр: \_\_\_\_\_

Сургалт эрхлэх байгууллага: \_\_\_\_\_ Нэгж: \_\_\_\_\_ Газар:  Амбулатори

Эмийн үйлдвэр  УА тасаг  Бусад \_\_\_\_\_

**Гардан үйлдэл:**  Амилуулах суурь тусламж, зүрх уушгины сэхээн амьдруулалт  
 Тариа хийх (судас тариа, булчин тариа, арьсан дор)  Зүрхний цахилгаан бичлэг хийх  
 Цусан дахь сахарын хэмжээг тодорхойлох  Ханах заслын холын бэлтгэл хийх  
 Ханах заслын ойрын бэлтгэл хийх  Хануурын боолт хийх  Ханах засал хийх  
 Уул өвсөн төөнө хийх  Харандаан төөнө хийх  Эмч бодисын төөнө хийх (Монгол төөнө)  
 Зүүлэх төөнө засал хийх  Хайрцган төөнө хийх  Шовгон төөнө хийх  
 Хатгуур засал хийх  Бүлээн зүү засал хийх  Сам соруул засал хийх  Соруул засал хийх  
 Шивүүр засал хийх  Усан дэвтээлэг засал хийх  Ороож боох дэвтээлэг хийх  
 Илж нухлах засал хийх  Шимжүүлэх бариа хийх  Жин засал хийх

Одоог хүртэл суралцагч эмчийн тухайн гардан үйлдлийг хийсэн тоо \_\_\_\_\_

Үнэлгээ	Хангалтгүй	Завсрын	Хангалттай	Ажиглагдаагүй/ үнэлэх боломжгүй
Хийх гэж буй үйлдлээ өвчтөнд тайлбарладаг. Өвчтөнөөс зөвшөөрлийн хуудас авдаг.				
Гарлан үйлдэл хийх бэлтгэлийг зохистой хийдэг.				
Халдваргүйжүүлэх үйлдлийг гүйцэтгэдэг, багаж хэрэгслийг аюулгүй хэрэглэдэг.				



Арга техникийг чадварлаг гүйцэтгэдэг.				
Өөрийн чадахгүй үйлдлийг ойлгож, шаардлагатай үед тусламж дууддаг.				
Багаж хэрэгсэл, материалыг цэвэрлэдэг				
Шаардлагатай бичиг баримтыг гүйцэт бичдэг.				
<b>Гардан үйлдэл хийх ерөнхий чадвар</b>				

Зөвлөмж:

- Сайн тал:
- Сайжруулах тал:

Бусад санал:

Сайжруулахын тулд зөвшилцөж, биелүүлэх үйлдэл:

Үнэлэгчийн гарын үсэг: \_\_\_\_\_

Суралцагч эмчийн гарын үсэг: \_\_\_\_\_

## НОМ ЗҮЙ

1. Зүү төөнө заслын суваг, сүвийн хэмжил зүй. Н.Төмөрбаатар Улаанбаатар хот. 2012 он
2. Зүү төөнө засал. Б.Бадарч, Б. Цолмонпүрэв. Улаанбаатар хот 1989 он.
3. Зүү төөнө заслын онолын үндэс. Н.Төмөрбаатар. УБ. 2010 он
4. Толгойн өвдөлтийг өрнө дорнын анагаах ухаанд оношлож эмчлэх арга Н.Төмөрбаатар, Д.Цэрэндагва, Б.Лагшмаа, С.Олдох УБ. 2001
5. "Basic theory of traditional Chinese Medicine", Shanghai College of Chinese medicine, 2016
6. "Clinic of traditional Chinese Medicine", Shanghai College of Chinese medicine, 2016
7. "Diagnostics of traditional Chinese Medicine", Shanghai College of Chinese medicine, 2016
8. Acupuncture Meridian Theory and Acupuncture points. Li Ding. Beejing, China. 1991
9. Хуанди нейжин
10. АШУУИС-ийн МАУОУС-ийн "Зүүний сүвийн байршилзүй" гарын авлага, 2021
11. АШУУИС-ийн МАУОУС-ийн "Зүү эмчилгээ" гарын авлага, 2021
12. Зүү төөнө заслын зонхилон тохиолддог өвчний оношилгоо эмчилгээ БНХАУ, Бээжин хот ( Англи хэлээр) 1988.
13. Н.Занди нар. Зүү эмчилгээ. УБ 2018 он
14. Clean Needle Tchnic manual, 7<sup>th</sup> editioan, Council of Colleges of Acupuncture and Oriental medicine, 2015
15. Н.Оюунцэцэг, Д.Цэнд-Аюуш, Н.Төмөрбаатар, Т.Алимаа, Монгол анагаах ухааны засал, Улаанбаатар, 2012
16. Maciocia G. The Practice of Chinese Medicine: The Treatment of Diseases with Acupuncture and Chinese Herbs. vol 2. Churchill Livingstone; 2nd edition (December 26, 2007); 2008.
17. Shanghai College of Traditional Medicine. (Translated by John O'Connor and Dan Bensky). Acupuncture: a comprehensive text. Eastland press. 1981
18. Tu Xi. Acupuncture China's wonder therapy. Foreign language press, Beijing; 2010
19. Guidelines for clinical research on acupuncture, WHO Regional Publications, Western Pacific Series, No.15, 1995,
20. ДЭМБ-ын, "Зүү төөнө заслын суваг сүвийн хэмжилзүйн стандарт", 2008